



ДУНДГОВЬ АЙМАГ
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/68

Тавин

Сумын баяр наадмын тов тогтоож,
комисс томилох тухай

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А/255 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардын хувьсгалын 102 жил, сум байгуулагдсаны түүхт 64 жилийн ойн баяр наадмыг 2023 оны 7 дугаар сарын 07,08-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Сумын баяр наадмыг зохион байгуулах ерөнхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга : Сумын Засаг дарга

Гишүүд: Морины комиссын дарга

Бөхийн комиссын дарга

Соёлын комиссын дарга

Шагайн харвааны комиссын дарга

Хэв журмын комиссын дарга

Аж ахуйн комиссын дарга

3. Сумын баяр наадмын салбар комиссуудын бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, гүйцэтгэх ажлын чиглэлийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

4. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2013 оны 18 тоот тогтоолоор батлагдсан журмыг хэрэгжүүлж, баяр наадмыг чанартай зохион байгуулж, гүйцэтгэх ажлын чиглэлийг бүрэн хэрэгжүүлж удирдлагаар хангаж ажиллахыг ерөнхий болон салбар комиссын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.УРАНЧИМЭГ

(D)/ZDTG2023/захирамж.docx

10-2010175

Сумын Засаг даргын 2023 оны 06 сарын 27-ны
өдрийн 11... тоот захирамжийн 1 дүгээр хавсралт
168



Аж ахуйн комисс:

Дарга: Б.Уранцэцэг ЗДТГ-ын дарга

Гишүүд: Э.Баяржаргал Санхүүгийн албаны дарга

Б.Даваажаргал Дунд сургуулийн захирал

Б.Уугансарнай Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч

Б.Биндэръяа Нийгмийн даатгалын байцаагч

Н.Цэрэнчунт Архив, Бичиг хэргийн ажилтан

М.Отгонтуяа ЗДТГ-ын үйлчлэгч

Ч.Урантуяа ЗДТГ-ын нярав

Ө.Уранбилэг Боловсролын ня-бо

Ж.Даваахүү Засаг даргын тамгын газрын слесарь

Б.Хаданчулуун Засаг даргын тамгын газрын Жолооч

М.Мөнхбат Гэрлийн монтёр

Морины комисс:

Дарга: Ё.Адилбиш 5-р багийн засаг дарга

Гишүүд: Э.Сэржмядаг 4-р багийн засаг дарга

Ю.Туяамаа 2-р багийн засаг дарга

Б.Загдзүсэм Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн

Б.Төмөрчөдөр 3 дугаар багийн Засаг дарга

С.Отгонбаяр Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон

гүйцэтгэгч

А.Цолмонбаатар Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн

Ц.Зана Жасын Их Хонгор ХХК-ны захирал

Н.Цэдэвдорж Жолооч

О.Ганбаатар Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

Б.Хаданчулуун Засаг даргын тамгын газрын Жолооч

Б.Түвшинбаяр Дунд сургуулийн туслах тогооч

Б.Түвшинтөгс Дунд сургуулийн жижүүр

Б.Сайнбилэг Дүйцүүлэх албаны цэрэг

Бөхийн комисс:

Дарга: Э.Ариунбилэг Улсын бүртгэгч

Гишүүд: С.Энх-Амгалан Хөлийн цэц

О.Пүрэвдаш Засуул

Д.Алтансүх Засуул

Ч.Хүрэлбат Засуул

Хэв журмын комисс:

Дарга: Ж.Батжаргал 1 дүгээр багийн Засаг дарга

Гишүүд: Г.Уранбилэг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Нарийн бичгийн дарга

Б.Өнөрболд Хэсгийн төлөөлөгч

О.Анхбаяр Цагдаа
Ц.Алтансарнай Төрийн сангийн мэргэжилтэн

Соёлын комисс:

Дарга: Ж.Эрдэнэцэцэг Соёлын төвийн эрхлэгч
Гишүүд: Н.Амгаланболд Соёлын төвийн хөгжмийн багш
Э.Дөлгөөн Соёлын төвийн Бүжгийн багш
О.Тэгшжаргал Соёлын төвийн Номын санч
С.Жавзандулам Соёлын төвийн Үйлчлэгч
Д.Дашгарав Хүүхдийн цэцэрлэгийн жижүүр
А.Цолмонбаатар Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч

Шагайн харвааны комисс:

Дарга: Д.Нацаг 1-р багийн иргэн
Гишүүд: А.Соронзонболд Дашчойнхорлин хийдийн Хамба лам
Б.Баярхүү 1 дүгээр багийн иргэн
Т.Баасансүрэн Дашчойнхорлин хийдийн лам

Нийт 46 хүн

Сумын Засаг даргын оны сарын
өдрийн дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Аж ахуйн комиссын хийх ажлын чиглэл

- Наадмын талбайн их цэвэрлэгээ хийх
- 00 янзлах
- Асарт болон морь мялаах 200 литр айраг эсгэх
- Тавгийн идээ бэлтгэх
- Наадмын тохижилтыг хангах, төв асрын ширээ сандлыг байрлуулах
- Наадмын гэрэл тогны асуудлыг шийдэх /мотор, моторын бензин, агаарын утас/
- Айрагдсан морьдын Бай шагнал гардуулах ажиллагааг зохион байгуулах /медаль, медалийн суурь, өргөмжлөл, хадаг, хул гэх мэт/
- Бүх төрлийн мандат зөвшөөрлийг бэлтгэж хуваарилах
- Тайлан гаргаж өгөх
- Комиссуудын хоолыг шийдвэрлэх
- Баяр наадмын нэгдсэн хөтөлбөрийг боловсруулан батлуулах
- Хүндэтгэлийн индер бэлтгэх
- Бөхийн засуулын дээл бэлтгэж бэлэн байдлыг хангах
- Нэгдсэн төсвийн тооцоог хийж тайланг гаргах
- Баяр наадмын холбогдолтой бүх материалыг салбар комиссуудаас авч архивлан архивт хүлээлгэн өгөх
- Хогийн сав будаж янзлах
- Далбааны иш бэлтгэх

Бөхийн комиссын хийх ажлын чиглэл

- Барилдах бөхчүүдийг бүртгэж, оноолт хийх, бөх тайлбарлах ажлыг зохион байгуулах
- Бөхийн боов, тавгийн идээг бэлтгэх
- Бөх цоллох болон засуул хийх хүмүүсийг бэлтгэх
- Бөхийн асар майхныг барьж наадам дуусмагц бүрэн хүлээлгэн өгөх
- Засуулын дээл болон Зодог шуудгийг хүлээн авч тоо ёсоор хүлээлгэн өгөх
- Шаардлагатай комиссын зардлын тооцоог гаргаж аж ахуйн комисст хүргүүлэх
- Тайлан гаргаж өгөх
- Холбогдох материалыг архивлаж ЗДТГ-т хүлээлгэн өгөх

Морины комиссын хийх ажлын чиглэл

- Морь уралдах зайг тогтоох
- Морины уралдааны замыг засч янзлах
- Морины комиссын гэр барих /вагончиг/
- Морь цоллох болон морь барих 5хүн бэлтгэх
- Морины мандат олгож тооцоо хийх
- Унаач хүүхдүүдийг даатгалд хамруулан хамгаалах хэрэгсэл хувцастай хурдны замд гаргах
- Айргийн тав болон зургаагаас аравт давхисан морьдын мэдээллийг Аж ахуйн комисс болон соёлын комисст тухай бүр нь гаргаж өгөх
- Айрагдсан морьдыг шагнал гардуулахад бэлэн байлгах
- Айргийн 10-аас хойшхи морины бай олгох

- Шаардлагатай комиссын зардлын тооцоог гаргаж аж ахуйн комисст хүргүүлэх
- Тайлан гаргах
- Морь гарааны болон барианы төхөөрөмж янзлах
- Зурхай засах
- Холбогдох материалыг архивлаж ЗДТГ-т хүлээлгэн өгөх

Хэв журам сахиулах комиссын хийх ажлын чиглэл

- Цагдаагийн хэсгийн автомашин, мотоциклийн бэлэн байдлыг хангах
- Худалдаа үйлчилгээ явуулах цэгийг тогтоох
- Автомашин, мотоциклийн зогсоол бэлтгэх
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд оролцох зөвшөөрөл, үйлчилгээний болон хогийн хураамжийн зөвшөөрөл олгож тооцоо хийх
- Наадмын үеэр хэв журам сахиулах үйл ажиллагааг хангаж ажиллах, зөвшөөрөлгүй морь дагах байдлыг зогсоох
- Морь барих үеийн дэг журмыг сахиулах
- Наадмын үеэр хог цэвэрлэх хүн ажиллуулах
- Шаардлагатай комиссын зардлын тооцоог гаргаж аж ахуйн комисст хүргүүлэх
- Хогийн сав складнаас гаргаж будаж янзлах
- Тайлан гаргаж өгөх
- Холбогдох материалыг архивлаж ЗДТГ-т хүлээлгэн өгөх

Соёлын комиссын хийх ажлын чиглэл

- Хөгжим техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллуулах
- Баяр наадмын нээлт, хаалтын үйл ажиллагааг зохион байгуулах
- Айргийн 5 болон 6-10-т давхисан морьдыг нийтэд мэдээлэх
- Айрагдсан морьдод шагнал гардуулах 5 хүүхэд бэлдэх
- Шаардлагатай комиссын зардлын тооцоог гаргаж аж ахуйн комисст хүргүүлэх
- Тайлан гаргаж өгөх
- Холбогдох материалыг архивлаж ЗДТГ-т хүлээлгэн өгөх